

БОДЛЕР, ШҮЛЭГ, ОНЬСОГО

М.Ууганбаяр¹

Роман Якобсон /Roman Jakobson/ хэлэхүйн сонголт /selection/ нэгдэл/combination/ гэсэн хоёр үйлдлийг авч үзэхдээ сонголт нь босоо тэнхлэг метафор, нэгдэл нь хэвтээ тэнхлэг метоним болно хэмээн шүлгийг хэлний талаас тайлбарласан байдаг. / Р. Якобсоны сонголт нэгдэл хэмээх ойлголт Соссюрин парадигматик синтагматик бүтэцтэй дүйдэг М У./ Р. Якобсон шүлгийн үүрэг нь хэлний нэгж буюу тэмдгийн хоорондын ижил чанарын зарчмыг сонголтын тэнхлэгээс нэгдлийн тэнхлэг рүү шилжүүлэх явдал гэж өгүүлсэн ба сонголт нь шүлэг нэгдэл нь үргэлжилсэн үг болдог хэмээсэн байна. Южин В. Холланд /Eugene W. Holland/ Р. Якобсоноос метафор метоним гэх тодорхойлолтыг зээлдэн авахын хамтаар шүлэг /verse/ үргэлжилсэн үг /prose/ гэх ялгааны оронд шүлэглигийн метафорч метонимч хэгжүүлэлт гэсэн ойлголтын талаар ярьж байна. Южин В. Холланд Шарль Бодлерийн /Charles Baudelaire/ шүлгийг метафорчаас метонимч болсныг заагаад энэхүү хувирал өөрчлөлт нь Шарль Бодлерийн шүлэг романтик шүлгээс модернист шүлэг тийш өөрчлөгдсөнийг ч хамтдаа бий болгож байгаа гэсэн ба энэ өөрчлөлт нь Бодлерийн шүлэгт метафор ба метоним нь тогтворгүй хоёрдмол эсрэгцлийг төлөөлөхгүй хэмээх утгатай юм. Южин В. Холланд Жиль Делёз Феликс Гваттари /Gilles Deleuze Felix Guattari/ нарын сэтгэгчдийн шизоанализын үзэл буюу утгажилтийн дараах дэг /postsignifying regime/ хэмээх онол дээр үндэслэн метафор зонхилох Шарль Бодлерийн эхний үеийн шүлгүүдийг капиталист харилцааны сүлжээс дунд утгын хайгуул шүлгийн үйлдвэрлэл гэж үзээд утгажилтын дараах сөрөг дэг хэмээж харин түүний сүүлийн үеийн шүлгийг метоним үүсгэгч утгагүй туршийг эрэх агуулга буюу утгажилтийн дараах эерэг дэг гэж ялгаж байна /Holland 1993:138-139; Akgul 2005:64-83/

Шарль Бодлерийн романтик шүлэглиг юм уу нийгэм цаг хугацааны гадна хүнийг байгальд эзэгнэх зохицлыг өгүүлэх метафорч шүлгүүдийг түүний одоо цагийн метонимч илгээмжүүд хам эхийн зонхилол болох модернизм нь хүчтэйгээр үгүйсгэдэг юм. Өөрөөр хэлбэл метафорч тогтолцоо нь ямарваа үг өөрөө байхгүй /in absentia/ түвшинд метонимч тогтолцоо нь одоо цагт /in prasentia/ байршина. Шарль Бодлерийн шүлгийн хувирал нь ийнхүү байгалийг ижилслийн объект болгон цагийн гадна байдлаар хэрэглэхээс хотын одоо цагийн дүр төрхийг товчоолох тийш чиглэх замаар хэрэгжжээ. Южин В. Холланд Шарль Бодлерийн 'Зэрэгцлүүд' /Correspondances/ 'Гоо сайхан' /La Beaute/ гэх хоёр шүлгийг харьцуулсан ба 'Зэрэгцлүүд'-д тэгш тэнцүү ил тод бүхэллийн метафорч дүрслэмжүүд олон байхад 'Гоо сайхан'-д гадаад төрх механик шалтгаацил зэрэглэлт харьцууллын метонимч дүрслэмж шаардагдана.

¹ Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Шарль Бодлерийн романтик буюу босоо тэнхлэгийн метафорч шүлгээс символист хэвтээ тэнхлэгийн метонимч шүлгийг бий болгосон хувьсгал нь үнэн хэрэгтээ Поль де Маны /Paul de Mann/ хэлсэнчлэн аллегорик найруулгын үүслийн асуудал болно. Босоо холбоонд бодит ахуй нь хийсвэр бодол сэтгэлийг сэргээн хөгжөөхөд хэрэглэгдэнэ. Тухайлбал, үнэр бол гэнэн цэвэр чанар нүгэл чивэл гэх зэрэг хийсвэржүүлэлттэй дуу авиа нууцлаг чинагуухь хүчтэй байгаль бол үнэмлэхүй нэгдлийн хуваагдмал үзэгдэлтэй хамаатай юм. Хэвтээ холбоо, таван мэдрэхүй нэг нь нөгөөтэйгээ гагнагдан ууссанаар үүсдэг. Үнэр өнгийг өнгө авиа дууг сэргээнэ. Символист шүлгийн энэхүү сэргээн дуудах аргыг синестез /synesthesia/ гэдэг билээ.

Бидний хувьд оньсогын хэл ба метафор метонимийн асуудал ихэд сонирхолтой байна.

Оньсого ба метафорыг харьцуулсан судлаачид оньсого түүний хариултын харьцааг метафор хийгээд метонимтэй адилтгажээ. /Cankara 2002.70-75/ Өөрөөр хэлбэл, оньсогыг задлах нь метафорч оньсогыг хариуг олох нь метонимч үйлдэл болдог байна. Дээрхээс үзвэл Шарль Бодлерийн синестез зэрэгцлийн /synesthesia or 'correspondance' / онолоос улбаалах утгаар оньсогыг таах мэдэх нь шүлгийн синестезлэгдэх үйл явц болдог гэж дүгнэлтэй.

Ном зүй

Бодлер Ш Цветы зла Санкт Петербург Изд "Азбука –классика 2004

Akgul A Oktay Rifat Şiirinde Guneşin Uc Hali Bilkent Üniversitesi Ekonomi ve Sosyal Bilimler Enstitüsü Yüksek Lisans Tezi Ankara 2005

Baudelaire Les Fleurs du Mal Ed. de Cluny Paris 1968 s 6

Cankara M Metafor Yaratma Eylemi Olarak Bilmece Milli Folklor Yil 14 Sayı 55 s 70-75 Ankara 2002

Holland Eugene W. Baudelaire ans Schizoanalysis Cambridge and New York Cambridge University Press, 1993

Jakobson R Two aspects of Language and Two Types of Aphasic Disturbances Language in Literature Ed. Krystyna Pomorska Stephen Rudy London The Belknap Press of Harvard University Press 1987

SUMMARY

In this article, author discusses about Charles Baudelaire's metaphorical and metonymical poems from structuralistic and schizoanalytical point of view. Also author compares riddles to Baudelaire's synesthesia or 'correspondance' method in poetry.